

Хүннүгийн урлагийн даяаршил

Бадамхатаны Бадма-Оюу^{1, *}

Товч агуулга: Хүннүгийн сэргэн мандалтын үе бол Евразийн тал нутгийн олон үндэстэн угсаатны явцад асар их өөрчлөлт авчирсны хэрээр уугуул урлаг хийгээд язгууртны хэрэглээний зүйлд ч өөрчлөлт явагдаж байсан нь хүннүгийн язгууртны бие даасан урлагт тогтсон дэг ёсыг бий болгож байжээ. Хүннү гүрний нийгэм, эдийн засгийн бүтэц төрийн өндөр зохион байгуулалттай болсноор Еврази даяар эзэнт гүрний төвт бүтцийг үүсгэн, урлагийн геополитикийн хувьд Евразийн нүүдэлчдийн урлагийн нийтлэг шинжийг агуулсан даяаршлыг бий болгож Хүннүгийн эзэнт гүрний стандарт урлагийн зүйлс Байгал нуур, Өмнөд Сибирь, Зүүн Азийн нутгаар тархаж Ойрх Дорнод хүртэл нэвтэрч эхэлсэн билээ. Хүннүгийн урлаг нь эд материал, технологийн хийгээд урлагийн техникийн хөгжил, угсаа соёлын харилцаа холбооноос эртний өвөг монголчуудын хэв шинжийг хадгалж, олон угсаа гарал, угсаа соёлын суурин дээр Евразийн урлагийн элементүүдийг хөгжүүлэх, даяарших явцад онцгой хувь нэмэр оруулсан их гүрэн байсныг өнөөгийн дэлхий дахины эртний түүхийн шинжлэх ухаанд эзлэх хүннүгийн нийгэм-соёлын судалгааны орон зай хийгээд археологийн баялаг олдвор хэрэглэхүүн бүрэн илэрхийлсээр байгаа билээ.

Түлхүүр үг: Евразийн нүүдэлчид, амьтны загварт урлаг, Хүннү төвт урлагийн стандарт, урлагийн даяаршил, тархац

НТӨ II мянганаас Евразийн тал нутгийг бэлчээрийн мал аж ахуй бүхий нүүдэлчдийн нийтлэг бүрэн эзэлж тэдгээр нь суурин соёл иргэншлээс тэс өөр өвөрмөц аж ахуй, амьдралын хэв маяг, морьтон дайчид, баатарлаг өвөг дээдэс, шүтлэг бишрэл бүхнийг агуулсан амьтны загварт урлагийн нийтлэгийг бий болгожээ. Сүүлийн үеийн судалгааны чиг хандлагаар тэдгээр нүүдэлчид нь эргэн тойрны улс, овог аймгуудтай харьцах худалдаа үйлдвэрлэлийн хамгийн дөт замыг нээж Евразийн даяаршлыг бий болгосон (Argent 2010; Miller et al. 2013) хэмээн үзэх болсон ба цаашлаад улс төр, нийгмийн өвөрмөц механизмыг бий болгож, нэгдмэл дотоод бүтэцтэй суурин иргэншлээс тэс өөр нийгмийн нэгдлийг бүтээж чадсан нь дэлхий дахины эртний түүхийн судалгааны нэгэн гол чиглэл болж ирлээ.

НТӨ III зууны үест Монгол нутагт нүүдэллэн аж төрж асан өвөг монгол гаралт сурвалжит овог аймгуудын улс төр, эдийн засгийн зохион байгуулалтын дор залгамж болон хүчирхэг улс бий болсон нь Хүннү гүрэн байлаа. Хүннүгээс өмнөх өвөг монгол нүүдэлчид нь хойт болон баруун хойт талаараа Өмнөд Сибирийн хар тугалгат хүрлийн үйлдвэрлэл, өмнөд болон зүүн өмнөд талаасаа цагаан тугалгат хүрлийн технологийн аль алиныг эзэмшсэн, өөрсдийн оюун санааны загварчлалыг төмөрлөгийн

эх үүсвэртэй холбон амьтны загварт урлагийг өндөр хэмжээнд хөгжүүлсэн Зүүн Евразийн хөгжлийн соёл технологийг түгээгч нар байсан нь Хүннүгийн улс төр, эдийн засгийн хөгжлийн хирээр улам дэлгэрэн хөгжсөн юм.

Судлаачид Хүннүгийн урлагийг НТӨ I мянган жилийн эхнээс олон зуун жилийн турш бүрэлдэн бий болсон соёлын уламжлалын эцсийн илэрхийлэл хэмээн үздэг бөгөөд нийгэм-улс төрийн дүрслэлийн хувьд хүннү нарын урлаг хамгийн эртнийх бөгөөд Скиф-Сибирийн ертөнцийн олон овог аймгуудыг эрхэндээ оруулснаар Төв Ази даяар хүннүгийн урлагийн нөлөөг авах нөхцөл бүрдэж эртний хэв шинжийг хадгалсан амьтдын хүчирхэг дүрслэл бүхий урлагийн зүйлс механикаар тархаж гайхамшигт угсаа соёлын орчин бүрдсэн хэмээн үздэг (Jacobson 1985: 113).

Хүннүгийн хүчирхэгжил мандалтын үе бол Евразийн тал нутгийн олон үндэстэн угсаатны явцад асар их өөрчлөлт авчирсны хэрээр ялангуяа хаад язгууртны хэрэглээний бэлэг тэмдгийн зүйлд ч өөрчлөлт явагдаж байсан нь Хүннүгийн язгууртны бие даасан урлагт тогтсон дэг ёсыг бий болгож байжээ. Түүхч Г.Сүхбаатар “Хүннү нарын хамгийн чухал бүтээлч ажиллагаа бол түрүүчийн үеийн туршлагыг өвлөн эзэмшиж хөгжүүлэхдээ хөрш орны ард түмний соёлоос зохих зүйлийг авч өөрийн соёлд шингээсэн явдал мөн гээд Ноён уулын язгууртны булшнаас гарсан нэхмэл болон хатгамал эдлэл дээр дүрслэгдсэн дүрслэлүүд нь тухайн үеийн өрнө зүгийн

¹ МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: badamxatan@yahoo.com

соёл иргэншилт орнуудын соёлыг шууд хуулбарлан авч тусгаагүй, харин нүүдэлчдийн өөрсдийн хэв загварт хослуулан буулгаж, тухайлбал шүтлэг хийгээд нүүдэлчдийн амьдралд хамгийн их эрхэмлэдэг амьтан, уламжлагдаж ирсэн загварт дүрслэлүүдийг сэдэв болон зохиомжинд оруулан урласан болохыг харуулж байна” хэмээн дүгнэжээ (Сүхбаатар 1980: 150).

Хүннүгийн газар нутгийн тэлэлттэй холбоотойгоор талын нүүдэлчдийн урлагийн элементүүд ялангуяа цоолбор урлагийн зүйлс НТӨ I зуунаас хойш Енисей рүү эрчимтэй нэвтэрч эхэлсэн бөгөөд өрнө дорнын олон улс оронтой улс төрийн идэвхитэй харилцааны үр дүнд Хүннүгийн амьтны загварт урлаг нь уугуул урлаг болон язгууртны төвт урлаг гэсэн хоёр үндсэн хоёр хэв шинжийг агуулж эхэлжээ.

Эртний нүүдэлчдийн уламжлалт уугуул урлагийн нэг болох өргөн хэрэглээний цоолбор аргаар үйлдсэн амьтны загварт дүрслэл бүхий бүсний арал чимэг бол НТӨ I мянганаас Монгол нутагт үүсч Умард Хятад, Минусын сав газарт өргөн дэлгэрсэн ба Хүннүгийн үе хүртэл олон зуун жил нүүдэлчдийн хэрэгцээнд тасралтгүй уламжилж ирсэн зүйл юм. НТӨ V зууны үеэс талын нүүдэлчдийн урлалд тэгш өнцөгт цоолборын арга технологи улам бүр хөгжсөнөөр худалдаа наймааны чиглэлээр хөрш зэргэлдээх улс аймаг руу тархах болжээ. Энэ хугацаанд бүсний арал чимгийн хийц, өгүүлэмж, хийх технологи зэрэгт бүс нутгийн онцлогийг харуулсан өөрчлөлтүүд гарч ирсэн бөгөөд тухайлбал, хөрш зэргэлдээх улс, аймгуудаар дамжин хэвлэх, шарах, шигтгэх зэрэг уламжлалт хийгээд шинэлэг аргыг хослуулан үйлдсэн ашиглаж үйлдсэн нь амьтны загварт урлаг бүхий бүсний арлын өөрчлөлт шинэчлэлтээс нь илэрхий харагддаг. Ийм эдлэл Хүннүгээс хойш Сарматийн үеийн археологийн дурсгалд нэлээд түгээмэл үлдсэн бөгөөд сарматийн үед амьтны биеийн үеүдийг цэгээр тэмдэглэж навчин хээ алга болсон нь Хүннүгийн урлагийн нөлөө ихэд орсныг илтгэдэг.

Хүннү нарын өвөг дээдэс Умард Хятадын нүүдэлчин овог аймгууд болон Хятадтай төмөрлөг боловсруулалтын хамгийн ойр харьцаатай байсны хувьд Төв болон Баруун Азиас “клазоне” буюу металл эдлэл дээр шил, паалан, чулуу болон бусад материалыг шигтгэж гоёх арга зэргийг нэвтрэхэд гол зуучлагч нар болж байсан нь Хүннүгийн үеийн гадаад харилцаа, соёл технологийн сүлжээний бас нэг илрэл бөгөөд улмаар Хүннүгийн хэв шинжит эдлэлийн нэг болсон нь харагдана. Ийм түүхэн урт удаан харилцааны туршид бүрэлдсэн уугуул амьтны загварт дүрслэл бүхий хүрэл эдлэл нь хүннүгийн үед нэгд, тал нутгийн гаралтай уугуул дүрслэл, хоёрт, суурин урлагийн тусгал бүхий орон нутгийн урлал, гурав, умардын овог аймгуудад зориулж дүрслэлийн дагуу хятадад хийсэн урлал гэсэн гурван хэв шинжийг бий

болгосон байв (Bunker 1997: 11).

Мөн энэ үед Хүннүгийн урлагт Хятадын төрт ёсны тэгш хэмт ёсны бэлгэдэл зүйн үзэл санаа болон бусад хэв шинжит элементүүд ч нэвтэрч эхэлсэн билээ. Ялангуяа Хүннүгийн үед улам дэлгэрсэн хоёр барсад бариулж буй чоно эсвэл хоёр барсад ноцуулж буй лууны дүрслэл бүхий ижил өгүүлэмжтэй хүрэл болон алтадмал бүсний арлууд нь мөн технологийн хувьд мөнгөн ус хийгээд алтаар шармалдах технологи хүннү нарт нэвтэрсэн байсныг илтгэдэг бол махчин шувуу, буга зэрэг тураг амьтантай давхар тулалдаж буй чоныг дүрсэлсэн байдал нь Халын урлаг, Скиф-Сибирийн урлагийн нэгдлийн жишээ болж өгдөг.

Эдгээр нь Хүннүгийн төрт улсын гадаад харилцаа, соёлын солилцоо эрчимжихийн хирээр урлагийн зүйл ч тэр хирээр хөгжиж Евразийн амьтны загварт урлагийн сонгодог сэдэв дээр тухайлбал, грифон, махчин шувуу хийгээд бусад амьтдын холимог хүчирхэг амьтдын загварчилсан дүрүүдийг бий болгож Хүннүгийн язгууртны стандартыг шинээр бий болгон хөгжиж байсныг харуулдаг юм. Ийм холимог амьтдын дүр хүннү нарын үеийн чимэг хийх урлагт НТӨ II зуунаас эрчимтэй нэвтэрч эхэлснийг илтгэх дурсгалууд Монгол нутаг дахь Хүннүгийн үеийн хаад язгууртны булшнаас илэрч олдоод байгаа нь Евразийн амьтны загварт урлагийн уран сэтгэмжийн хөгжлийн оргил үетэй давхцана. Пазырыкийн хожуу үеийн амьтны загварт урлагт ч энэ үеийн урлаг соёлын нийтлэг тогтолцооны дагуу тэнгэр газрын хүчирхэг амьтдын нийлмэл дүр болох грифон-морьд зэрэг гайхамшигт дурсгалуудын хангалттай баримт бий. Хүннүгийн язгууртны бэлгэдэл зүйд ийм хүчирхэг амьтдын нийлмэл дүр улам бүр төгөлдөржиж байсан нь Монгол нутагт малтан судлаад буй хэд хэдэн Хүннүгийн язгууртны дурсгалт газруудаас илэрсэн олдворын хэрэглэхүүн гэрчилдэг. Тухайлбал, Хүннүгийн язгууртны Гол мод-1, Гол мод-2 зэрэг дурсгалт газраас луун толгойтой, шувуун цээжтэй, далавчтай хүчирхэг амьтныг дүрсэлсэн алт, мөнгө, хүрэл чимэг цөөнгүй илэрч олдоод байгаа нь өндөр дээд шаньюйн язгуур угсааны илэрхийлэл юм.

Энэхүү Хүннүгийн язгууртны нийлмэл амьтдыг багтаасан дүрслэл нь эртний өвөг монгол аймгуудаас гаралтай загварчилсан чонын дүрслэлийг тэг болгон бүтээсэн сонгодог монгол загвар гэж үзэж болох бөгөөд одоогоор хамгийн олон загвар хийцтэй илрээд байгаа төдийгүй цаашлаад энэхүү чоно тэгт дүрслэлийн загвар нь чоно-луу тэгт амьтны нэгдлээр язгууртны урлагийн хүчирхэг холимог амьтдын үндсэн загвар болон уламжилсан байжээ хэмээн үзэж болно.

Хүннүгийн язгууртны урлагт ийм хүчирхэг нийлмэл амьтнаас гадна ганц эвэрт болон ямаа, гөрөөс зэрэг туурайтан амьтны дүр бүхий алт, мөнгө,

хүрлээр хийсэн эдлэлүүд нь хэрэглээний хувьд сүйх тэрэгний гоёл, адууны хазаар, хударга, хөмөдрөгний чимэг, хазаарын товруу, хазаарын духавч зэрэг чимэг байх нь олонтаа. Ганц эвэр нь тухайн амьтныг эгэлгүй болгож үзүүлэхийн хажуугаар үүнийг эзэмшиж байгаа хүний нийгмийн статусын шууд илэрхийлэл болох бэлгэдлийн зүйл юм. Ганц эвэртийн дүрслэл бүхий хөмөл мөнгөн эдлэлүүд нь хэлбэрийн хувьд гонзгой болон дугуй хоёр янз байх бөгөөд хүннүгийн язгууртны булшны малтлага судалгаа бүрт ийм хэрэглэхүүн бий гэж хэлж болно. Зориулалтын хувьд чий будаг, хүрэл тоноглол бүхий морин тэрэг олдсон булшнуудаас гарсан нь морины чимэг болохыг баталж дугуй чимэглэл нь хөмөдрөг, гонзгой хэлбэртэй нь хударганы чимэглэл гэж үзжээ (Ерөөл-Эрдэнэ 2011: 48).

Хүннүгийн хаад язгууртны хэрэглээнд дүрслэж буй амьтныхаа эрч хүч, хөдөлгөөн, бэлгэдлийг улам уран яруу гаргах болсны зэрэгцээ зарим соёлын нөлөөгөөр шинэ элементээр баяжиж эхэлсэн нь юм. Хүннүгийн цоолбор бүсний аралд Хань улсын урлагт дүрслэгдэх хүн, байгаль буюу уул, ургамал дүрслэх арга нэвтэрснийг зарим судлаачид Чжоу улсын үеэс тахилын сав суулганд өргөнөөр дүрсэлдэг “Бо шаньлу” буюу тахилга шүтлэгт уулыг дүрсэлдэгтэй адилтгаж үзжээ (Psarras 2003: 120). Ийм уул ус, мод ургамал зэрэг байгаль орчны үзэгдлийг багтаан дүрсэлсэн цоолбор бүсний аралд туурайтан амьтны эвэр, сүүлийг модны мөчир зэрэгт уусган дүрсэлсэн байх нь элбэг. Ноён уулын булшнаас илэрч олдсон сарлаг (хонин гөрөөс) үхрийг дүрсэлсэн мөнгөн хөмөл эдлэл, мөн тус уулнаас олдсон эсгийн ширдэг дээрх мод ургамал зэрэг нь Хүннүгийн уугуул дүрслэлээс өөр хэв шинжтэй байсан бөгөөд судлаачдын дунд Хань улсын урлагийн нөлөө, эсвэл бүр нөгөө талаас Ахаменидын Иранаас гаралтай гэхчлэн тайлбарлаж байсан бол сүүлийн үед судлаачид Хүннүгийн урлагийг дүрслэлийн өгүүлэмжийн хувьд суурин соёл иргэншлээс ангид учир тал нутгийн гаралтай (Jacobson 1985: 135), өөрийгөө загварчлах шинэ стратегийн бүтээл (Andreeva 2024: 185) хэмээн үзэх хандлага хэдийнээ бий болжээ. Тийм учир Ноён уулын сарлаг нэрээр алдаршсан энэхүү эдлэлийг цэвэр Хүннүгийн урлагийн сэдэв дээр Скиф болон Умард Хятадын урлагийн холимог шинжийг шингээн урласан тухайн үеийн Хүннүгийн урлагийн даяаршлын цоо шинэ хэв шинж хэмээн бусад ижил цаг үеийн олдворуудтай харьцуулсны үндсэн дээр үзэх боломжтой юм. Ийм гөвгөр гүдгэр, ханан хээ, сүлжмэл, хажмал арга техник нь талын нүүдэлчдээс Зүүн Чжоу улсын үед Хятад газарт нэвтэрсэн гэж үздэг (So/Bunker 1995: 63) (Зураг 1).

Евразийн улс төрийн ландшафт дээр гол тоглогч болсон хүннү нарын урлагт холын болон ойрын

улс гүрнүүдтэй харьцах эдийн засаг, улс төрийн хэрэгцээ шаардлагаас үүдэн соёлын солилцооны ийм хэмжээний шилжилт байх нь зүй ёсны хэрэг бөгөөд хүннү нар Евразийн түрүү төмрийн үеийн Амьтны загварт урлагийн сонгодог сэдвийг өөрийн стандарт хэмнэлд оруулсан нэг жишээ нь Ноён уулын ширдэг билээ.

Одоогийн байдлаар Ноён уулын 6-р булш, Гол модны 20-р булш, Дуурлиг нарсны 2-р булш зэрэг Хүннүгийн язгууртны археологийн дурсгалуудаас эсгий ширдэгний зүйлс илэрч олдоод байгаагаас Ноён уулын 6-р булшны ширдэгний дүрслэл хамгийн онцгой өгүүлэмжтэй нь юм. Уг ширдэг дээр дүрсэлсэн араатан амьтанд бариулан амь тэмцэлдэн буй буга, бух зэрэг туурайтан амьтад хийгээд барьсан ангаа лавшруулан барих гэж улангасан довтолж буй загварчилсан араатан амьтдын сүрлэг дүрслэлийг хос хосоор нь хэд дахин давтан дүрсэлсэн нь өгүүлэмжийн хувьд тухайн дайн тулаант эрин үеийн сүр хүч, ялалтын бэлэг тэмдэг болсон тулалдан тэмцэлдэж буй амьтдыг дүрслэх сонгодог сэдвийн дагуу өнгө бүрэх, алаглуулан урлах технологи ашиглан нутгийн уугуул амьтдын дүрийг ашиглан ирвэс-грифоны нийлмэл хүчит амьтны хамт дүрсэлжээ. Хүннүгийн язгууртны Ноён уулын ширдэг хэмээн алдаршсан энэхүү дурсгалын амьтдын өгүүлэмжийг зарим судлаачид Пазырыкийн урлагийн дараагийн шатанд Хүннүгийн элементүүдээр баяжуулж урласан хувилбар гэж үздэг



Зураг 1. Ноён уулын 6-р булшны хөмөдрөгний мөнгөн чимэг (ОХУ-ын Санкт-Петербургийн Эрмитаж музейд бий. Елихина 2017: 50)

бөгөөд хивс ширдэг урлалын хувьд Скиф, Сарматийн хүрээнд үзэгдээгүй технологиор үйлдсэн ба он цагийн хувьд НТ II зуунаас өмнө буюу Ноён уулын булшнаас илүү өмнө хийгдсэн байх ёстой гэж үзсэн байдаг (Bunker 1970: 108).

Эндээс үзэхэд Хүннүгийн нийгмийн дээд давхарга язгууртны хэрэглээнд бий болсон урлагийн зүйлс тэдний гадаад харилцааны чиглэл нэмэгдсэнийг илэрхийлэх ба нь эдийн засаг хүчирхэгжихийн хирээр бараа бүтээгдэхүүн өсөн нэмэгдэж худалдаа наймаа, бэлэг солилцоо, дайн тулааны замаар авч байсан харь гаралтай эдлэл хэрэглэл болон төр нийгмийн бэлгэдэл зүйн тогтолцооны сэдэв зохиомжийн дагуу урласан урлагийн зүйлсээс бүрдэж байна. Ялангуяа хамгийн ойрын хөрш Хань улстай худалдаа соёлын харилцаа идэвхитэй байсныг Хүннүгийн язгууртны булшнаас илэрч олддог хятад гаралтай бүтээгдэхүүнүүд гэрчилдэг. Хань улсын урлагт ч мөн хүннү гаралтай элементийн өөрчлөлт үзэгдэж эхэлсний сацуу өмнөд хөршөөс гадна өрнө дахины соёл иргэншилт орнуудын соёлын нөлөө ч шууд болон шууд бус замаар хүннүд ирж байжээ (Ерөөл-Эрдэнэ 2009: 109). Тухайлбал, Эгийн голын сав нутагт малтсан хүннү булшнуудаас шил болон “Египетийн шаврын хольц” хэмээн тодотгосон фаянс маягийн шаазан эдлэл цөөн тоотой олдсоныг Бактриар дамжин орж ирсэн гэж үзжээ. Үүнээс гадна Дэрстэйн булшнаас гарсан сувс, дун, шилэн эд зүйлс, Бага газрын чулууны Ихэрийн амны жирийн иргэдийн булшнаас гарсан хүний дүрс бүхий эдлэл, салаавч дүрстэй чулуун зүүлт (Египетийн Бес бурхны хөрөг) зэрэг хүннү нарын өрнө дахинтай харилцаж байсныг илтгэх олон баримтуудыг дурдаж болно (Ханичёрч, Амартүвшин 2006: 146; Ерөөл-Эрдэнэ 2011: 111).

Ийнхүү Хүннү гүрний нийгэм, эдийн засгийн бүтэц төрийн өндөр зохион байгуулалттай болсноор Еврази даяар эзэнт гүрний төвт бүтцийг үүсгэн, урлагийн геополитикийн хувьд Евразийн нүүдэлчдийн урлагийн нийтлэг шинжийг агуулсан даяаршлыг бий болгож Хүннүгийн эзэнт гүрний стандарт урлагийн зүйлс Байгал нуур, Өмнөд Сибирь, Зүүн Азийн нутгаар тархаж Ойрхи Дорнод хүртэл нэвтэрчээ (Andreeva 2022: 41). Хүннүгээс хойш хүннү төвт соёлын хэлбэрийг уламжлан хадгалсан шинэ соёлууд Өмнөд Сибирыг бүрэлдэн бий болсон нь Тувагийн Улуг-Хем, Алтайн Булан-Кобин, Минусын Таштык зэрэг соёлын иж бүрдлүүд билээ. Тагар-Таштыкын соёлын шилжилтийн үед л Минусын хотгорт цоолбор урлагийн зүйлс нэвтэрч Енисей хүртэл тэлсэн бол Умард Хятадад нэлээд эрт нэвтэрсэн байсан нь Ордос өмнөд хөрш нутагтай харилцаа илүү идэвхитэй байсныг харуулдаг.

Хүннүгийн талын эзэнт гүрний нутагт умард зүгт өмнөд Сибирь, өмнө зүгт Цагаан хэрэм хүртэл өргөжин

тэлж Төмрийн түрүү үеийн хүн ам хийгээд соёлын харилцааны явцыг тодорхойлох явдалд одоогийн Монгол улсын хойд, урд хил залгаа бүс нутгийн археологийн судалгаа чухал үүргийг гүйцэтгэнэ. Сибирийн нутагт малтан судалсан Хүннүгийн үеийн дурсгалт газрууд нь гадаад байдлаараа нэг талаар хожуу Скифийн хэв шинжтэй нөгөө талаар Хүннүгийн оршуулгын дурсгалтай төстэй боловч олдвор эд өлгийн зүйлийн хувьд хүннүгийн үеийн хэв шинжийг хадгалсан олдворууд байсан ба хамгийн сонирхолтой нь Хүннүгийн амьтны загварт урлагийн зүйлс олноор илэрсэн байдаг. Терезин, Сидоровка зэрэг Хүннүгийн үеийн дурсгалт газраас хэд хэдэн бүсний арал, бүсний чимэг, хүрэл толь, сав суулга, гоёл чимэглэлийн зүйлс байсан бөгөөд хоёр бар луутай тэмцэлдэж буй дүрслэлтэй бүсний арал, зургаан махчин шувууны толгой бүхий бүсний арал, оюу болон шүр чулуугаар шигтгэж чимсэн алтадсан арал зэрэг нь Өвөр Байгалаас мөн илэрч олддог нь хүннү төвт орон нутгийн хувилбарууд энэ бүс нутагт сайтар хадгалагдсаны жишээ болж байна.

Харин Хятадын зүүн хойд Ляонин мужаас Шинжаан хүртэлх талын бүс нутгийн хүннү болон өвөг хүннү нартай холбогдох археологийн дурсгалуудыг булшны ерөнхий зохион байгуулалт, оршуулгын зан үйл, хүннүгийн хэв шинжит олдворууд болон бичгийн эх сурвалжаас үндэслэгдэн “Талын соёлын нийтлэг”-т хамруулж үзэх ба Ордос зэрэг бүс нутгийн онцлог урлагийн зүйлсийг хийсвэрлэлийн шинэ зэрэг Хань улсаас нэвтэрсний жишээ болгон авч үзэж болно.

Ийнхүү Хүннүгийн урлагийн хэв шинж одоогоор хойд зүгт ОХУ-ын Минусын хотгор, Өвөр Байгал, урагшаа Хятадын Шинжаан, Өвөр Монгол, Ляонин зэрэг мужаар тархалт өндөртэй бөгөөд урлагийн зүйлс нь цэвэр хүннү гаралтай эдлэл хийгээд хүннү загварт эдлэл гэсэн хоёр хэв шинжтэй олддог. Хүннү нар эд материал, технологийн хийгээд урлагийн техникийн хөгжил, угсаа соёлын харилцаа холбооноос эртний өвөг монголчуудын хэв шинжийг хадгалж, олон угсаа гарал, угсаа соёлын суурин дээр Дорнод болон Умард Азийн урлалын элементүүдийг хөгжүүлэх, даяарших явцад онцгой хувь нэмэр оруулсан их гүрэн байсныг өнөөгийн дэлхий дахины эртний түүхийн шинжлэх ухаанд эзлэх хүннүгийн нийгэм-соёлын судалгааны орон зай хийгээд археологийн баялаг олдвор хэрэглэхүүн бүрэн илэрхийлсээр байгаа билээ.

Abstract

Globalization of Xiongnu Art

Badamkhatan Badma-Oyu

The period of the Xiongnu renaissance marked a time of profound transformation in the ethnogenetic processes of numerous groups across the Eurasian steppe. During this era, the symbols employed by rulers and the aristocracy also evolved, establishing a distinct order within the independent artistic tradition of the Xiongnu elite. The social and economic organization of the Xiongnu Empire characterized by a highly structured and centralized state system, fostered imperial cohesion across vast regions of Eurasia. In terms of artistic geopolitics, this centralized framework facilitated a form of cultural globalization that integrated the shared features of Eurasian nomadic art. Standardized artistic objects produced within the Xiongnu Empire circulated widely, extending from the Lake Baikal region and southern Siberia to East Asia, and even reaching the Middle East.

Ongoing socio-cultural research on the Xiongnu within the field of ancient world history continues to demonstrate that they represented a major power that preserved key characteristics of the ancient mongols through their material culture, technological and artistic achievements, and ethnocultural interactions. Moreover, the Xiongnu's made a distinctive contribution to the globalization of East and North Asian artistic elements, synthesizing influences from a wide range of ethnic and cultural traditions.

Keywords: Eurasian nomads, animal-style art, Xiongnu-centered artistic standard, globalization of art, distribution

Ном зүй

Амартүвшин, Ч., Ханичёрч, В. (2010). Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага газрын чулуу. УБ.

Andreeva, P. (2022). Re-making animal bodies in the arts of Early China and North Asia: Perspectives from the Steppe. Early China, doi:10.1017/eac.2022.7.

Argent, G. (2011). At home with the good horses: Relationality, roles, identity and ideology in Iron Age Inner Asia. University of Leicester.

Bunker, E.C., Chatwin, B.C., Farkas, A.R. (1970). Animal Style Art from East to West. The Asia Society Inc, USA.

Ерөөл-Эрдэнэ, Ч. (2009). Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын судалгаа (Гол модны дурсгалт газрын хэрэглэгдэхүүнээр). Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. УБ.

Jacobson, E. (1985). The Stag with Bird-Headed Antler Tines: A Study in Image Transformation and Meaning. Bulletin of the Museum of Eastern Antiquities. No.56.

Miller, B.K., Ursula, B. (2013). Beasts of the North: Global and Local Dynamics as seen in Horse Ornaments of the Steppe Elite. Asian Archaeology, Vol.1, Beijing.

Minyaev, S. (2000). The Origins of the Geometric Style in Hsiung nu Art. Kurgans, Ritual Sites and Settlements: Eurasian Bronze and Iron Age. Oxford, Archeopress.

So, J.F., and Emma C. Bunker, E.C. (1995). Traders and Raiders on China's Northern Frontier. Smithsonian Institution.

Сүхбаатар, Г. (1980). Монголчуудын эртний өвөг. Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал (МЭӨ IV –МЭ II зуун). УБ.

Psarras, S-K. (2003). Han and Xiongnu; A Re-examination of Cultural and Political Relations. Monumenta Serica. Journal of Oriental Studies, Sankt-Augustin, Germany, Vol.51.

Received: Nov. 18, 2025; Revised: Dec. 1, 2025; Accepted: Dec. 10, 2025

